

ШТАБЫН ДАДЛАГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙ

Ч.Баттулга

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга: *Офицерын бүрэлдэхүүний албаны мэдлэг, дадлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, албан тушаалаар хүлээсэн үүргийн дагуу анги, салбарыг удирдахад дадлагажуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх онцлогтой юм.*

Түлхүүр үгс: *Штаб, цэргийн сургалт, мэргэжлийн ур чадвар, штабын дадлага,*

Оршил

Хилийн цэргийн анги, салбарын сургалт бэлтгэл нь тухайн хариуцсан хилийн хэсгийн онцлог, хилийн цагийн байдал, байгаль, цаг уур зэрэг олон хүчин зүйлстэй харилцан хамааралтайгаар зохион байгуулагдаж байдаг хэдий ч зөвхөн хариуцсан хэсгийн хилийн халдашгүй дархан байдлыг хангах албаны хэрэгцээн дээр төвлөрөх шаардлагатай нь бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн үндсэн онцлог болж байгаа юм.

Штабын дадлага нь офицерын бүрэлдэхүүнийг улсын хил хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цагийн байдлыг зөв түргэн үнэлэх, даргаас шийдвэр гаргахад нь шаардлагатай тооцоо, саналыг авч тодорхой гаргаж илтгэх, даргын шийдвэрийг төрөл бүрийн удирдлагын баримт бичиг болгон (зурган, бичмэлээр) боловсруулах, холбооны янз бүрийн хэрэгслүүд, цэргийн далдуур удирдлагын бичиг баримтуудыг ашиглах дадлага, чадвартай болгодог.

Мөн офицеруудын бэлтгэлийг төгөлдөржүүлэх, оператив - тактикийн тооцоо гаргах ажиллагааны урьдчилсан төлөвлөлт, цагийн байдлыг үнэлэх дадлага, чадварыг олгох, улсын хил хамгаалалт, ажиллагааг удирдахад штабын офицеруудыг баримт бичгийг боловсруулан хөтлөх, ашиглахад дадлагажуулах үндсэн сургалт болдогоороо онцлогтой.

Нэг.Штабын дадлага, түүний зорилго, хэлбэр, бэлтгэж явуулах журам

Штабын дадлага гэдэг нь захирагч, дарга нарын удирдлага дор тактикийн нэг цагийн байдалд төрөл бүрийн байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах, явуулах үед штабын офицеруудыг албан тушаалын үндсэн үүргийг хэрэгжүүлэх, тэдгээрийн харилцан ажиллах дадлага, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн штабын бэлтгэлийн сургалтын нэг хэлбэр юм.

Штабын дадлагын зорилго:

- Тухайн албан тушаалд ажиллагч офицеруудын бэлтгэлийг

төгөлдөржүүлэн байлдааны бэлэн байдлыг зохих түвшинд байлгах, цэргийг удирдахад захирагч, штабын гар нийлэмжтэй ажиллагааг дээшлүүлэх;

- Оператив-тактикийн тооцоо гаргах, байлдааны ажиллагааны төлөвлөлт, цагийн байдлыг тогтоох явцад удирдлагын орчин үеийн техник, хэрэгслийг ашиглах дадлага, чадварыг нэмэгдүүлэх;

- Офицеруудын бэлтгэлийн түвшин, цэргийг удирдахад штабын ажлын шинэ арга, хэлбэрүүд, техник хэрэгсэл эзэмших, баримт бичгүүдийг боловсруулах чадварыг шалгах;

- Суралцагсдад ёс суртахуун, сэтгэл зүйн чанарыг төлөвшүүлэх үндсэн зорилгыг хэрэгжүүлдэг.

Штабын дадлагыг дэвшүүлсэн зорилго, оролцож байгаа бүрэлдэхүүн, боловсруулж байгаа асуудлын цар хүрээнээс нь хамааруулан *хэсэгчилсэн* ба *нэгдсэн* гэж ангилна.

*Штабын хэсэгчилсэн дадлага*²²³ гэдэг нь төрөл мэргэжлийн цэргийн тасаг, алба, штаб, ар тал, техникийн анги, салбар бие дааж явуулах дадлага бөгөөд энэ нь офицеруудыг үндсэн үүрэгт нь сургах, төрөл бүрийн стратеги-тактикийн тооцоо гаргах, байлдааны баримт бичиг боловсруулахад дадлагажуулах, анги, салбарын байлдааны ажиллагааны хангалт, харилцан ажиллагаа зохион байгуулах, удирдлагаар хангах ажиллагаанд сургах зорилготой.

*Штабын нэгдсэн дадлага*²²⁴ нь анги, байгууллагын штаб, салбар, нэгжийн удирдлагын бүрэлдэхүүн захирагч /дарга/-ийн удирдлагаар нэг сэдэв бүхий тактикийн цагийн байдал дээр цэргийг удирдах ажиллагааг цогцолбороор хэрэгжүүлдэг дадлага юм. Үүнд анги, байгууллагын штаб, ар тал, техникийн офицерууд болон хүч нэмэгдүүлсэн анги, салбаруудын удирдлага оролцоно.

Штабын дадлагын сэдвийг анги, байгууллагын захирагч /дарга/ сургуулийн жилд дэвшүүлсэн зорилт, удирдлага, штабын бэлтгэл, жигдрэлтийн түвшин, штабын дадлагын төрлөөс хамаарч тогтооно.

Штабын дадлагын сэдэв нь янз бүрийн цагийн байдалд цэргийн хөдөлгөөн үйлдэх, газар орон дээр байрлах ба байлдааны ажиллагааны аль нэг төрлийг зохион байгуулж явуулах үеийн штабын ажлын үндсэн асуудлуудын аль нэгийг болон хэд хэдэн асуудлуудыг хамардаг.

Тухайлбал, штабын нэгдсэн дадлагын сэдвийн агуулга нь дараах асуудлуудыг хамарч болно. Үүнд:

- Анги, салбаруудыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх үед цэргийг удирдах, байнгын байрлалаас хөдлөгөөн үйлдэн хүч хуралдуулах районыг эзлэх;

- Байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх үеийн удирдлага, харилцан ажиллагаа, бүх талын хангалтыг төлөвлөх, зохион байгуулах;

²²³ Ц.Ганболд, Д.Баатар “Штабын сургалт бэлтгэл” УБ., 2013 он 64 дэх тал

²²⁴ Ц.Ганболд, Д.Баатар “Штабын сургалт бэлтгэл” УБ., 2013 он 65 дах тал

- ҮОХЗ, нэн өндөр цэцтэй зэвсгээс хамгаалах ажлыг зохион байгуулах, тэдгээрийг хэрэглэсэн үед бий болсон хөнөөлийн хор уршгийг арилгах, байлдах чадварыг сэргээн босгох;

- Удирдлагын байруудыг байрлуулах, тэдгээрийг шилжүүлэн байрлуулах, удирдлагыг нэг байрнаас нөгөөд шилжүүлэх, агаарын КБ-наас цэргийг удирдах;

- Үндсэн төрлийн болон уламжлалт бус байлдааныг ажиллагааг зохион байгуулж явуулах, дайсны тагнуул, хорлон сүйтгэх бүлэг, агаарын десанттай тэмцэх;

- Жижиг бүлгээр түйвээх, тогтоон барих байлдааны ажиллагааг зохион байгуулж явуулах гэх мэт тактикийн

а. Штабын дадлагад бэлтгэх:

Штабын дадлагын бэлтгэл ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Анхны өгөгдөхүүнийг тодорхойлох;
2. Дадлага явуулахад шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулах;
3. Дадлага удирдах захирагч, туслагч, суралцагчдын бэлтгэх;
4. Дадлага явуулах байр, материал хангалтыг бэлтгэх зэрэг асуудлууд багтана.

Штабын дадлагын анхны өгөгдөхүүнд:

- Сэдэв, зорилго, сургуулийн асуудлууд, суралцах, бүрэлдэхүүн, явуулах хугацаа;

- Дадлага явуулах байр, район;

ажиллагааны өрнөлт, хөгжилттэй уялдсан, үүссэн цагийн байдалд нийцсэн хувилбаруудаар байлдааны ажиллагааг зохион байгуулж явуулах бололцоотой, тухайн анги, салбарын штабын бэлтгэлийн талаар тулгамдаж байгаа зорилтуудыг шийдвэрлэхийг эрмэлзсэн аль нэг асуудлыг хамарсан байвал зохино.

Гэхдээ штабын дадлагын сэдвийг хэт өргөн хүрээтэй, том асуудлыг сонгон авах нь түүнийг бэлтгэх, дадлагыг тогтоосон норматив хугацаанд явуулж, сэдэв, зорилгыг бүрэн хангахгүй боломжийг алдагдуулж, улмаар штабын дадлагын ач холбогдол буурах, бие бүрэлдэхүүнийг залхаахад хүргэдэг.

- Моторесурс, материал хангалт зэрэг дараах асуудлуудыг тусгана.

Анхны өгөгдөхүүнийг тодорхойлсны дараа штабын дадлага явуулах төлөвлөгөө, тактикийн даалгавар баримт бичгүүдийг боловсруулна.

Штабын дадлагын төлөвлөгөө:

Штабын дадлагын сэдвийг тодотгох (тодорхойлох) явцад захирагч дадлагын тактикийн агуулгыг онцлон үзэж, сэдвийн боловсруулалтыг ямар нөхцөлд хэрхэн эхлэх, ямар үндсэн шатуудад штабын ажлыг тодотгон гаргах, хэрхэн дуусгахыг тодорхойлно.

Штабын дадлагын төлөвлөгөөг (цэргийн байр зүйн зураг)²²⁵ дээр боловсруулж дараах зүйлийг тусгадаг. Үүнд:

- Анхны өгөгдөхүүн
- Тактикийн ажиллагааны

бодлого

- Эхлэх байдал буюу дадлага эхлэх үеийн талуудын байдал ба бүлэглэл, тал бүрийн дээд анги, салбарын үүргүүд, тэдгээрт гаргах захирагч нарын шийдвэрүүд, суралцаж байгаа штабын өмнөөс гаргах шийдвэр, хөршүүдийн үүрэг, сургуулийн асуудлыг боловсруулах явцад үүсэх цагийн байдал.

- Захирагчаас авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

- Дадлагын район руу штабыг гаргах журам, хийсвэр цаг зарлах журам, тактикийн даалгавар гардуулах, дадлагын явцад суралцагчдын ажлын багтаамжийг тодорхойлох, офицеруудын илтгэлийг сонсох, штаб болон тасаг, албадын офицеруудын ажилд хяналт тавих, захирагчийн шийдвэрийг хүргэх, боловсруулсан баримт бичгийг шалгах, дадлагын дүн гаргах журам.

Түүнчлэн байлдааны ажиллагааг зохион байгуулахад штабт шаардлагатай хугацааг тусгасан дадлагын үндсэн үзүүлэлтүүдийг тусгана.

Штабын нэгдсэн дадлагыг штабын дарга удирдаж байгаа бол төлөвлөгөөг захирагчаар батлуулна. Дадлагыг газар орон дээр явуулах үед төлөвлөгөөг дээд шатны захирагчаар батлуулах ба хэсэгчилсэн дадлагын төлөвлөгөөг гол төлөв штабын дарга батлана.

б. Штабын дадлагыг удирдаж явуулах:

Штабын дадлагыг явуулах журам²²⁶ ба аргачлал нь түүний төрөл, сэдэв, сургуулийн зорилго, Суралцагчдын бэлтгэлийн түвшин, дадлага явуулах байр зэргээс хамаарна. Үүнтэй уялдан дадлагыг:

1. Тооцоо, санал, өгөгдөхүүн бэлтгэх;

2. Байлдааны ажиллагааны төлөвлөлт, эсвэл явцад цэргийг удирдах асуудлуудыг боловсруулах гэсэн асуудлуудаар явуулж болно.

Газар орон дээр явуулах штабын нэгдсэн дадлага нь байнгын байрлалаас эсвэл, ангийн удирдлагыг дадлага явуулах районд гаргаснаар эхэлж болно.

Энэ үед “Цугларалт” дохиогоор гаргах ажиллагааг хэрэгжүүлж болно. Суралцагчдыг “Цугларалт” дохиогоор ажиллах үед захирагч:

- Ангийн жижүүрийн зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журам;
- Ангийн удирдлагын офицеруудын цугларалт, хангалт

²²⁵ В.Жавхланцогт, Ж.Өвгөнбүргэд, “Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь” УБ., 2017 он 77 дах тал

²²⁶ Ц.Ганболд, Д.Баатар “Штабын сургалт бэлтгэл” УБ., 2013 он 24 дэх тал

үйлчилгээний салбаруудын байлдааны бэлэн байдалд шилжих ажиллагаа;

- Офицеруудын дохиогоор ажиллах, өөрийн үүргээ мэдэж байгаа болон дэс дараалалтай гүйцэтгэх чадвар;

- Бие бүрэлдэхүүний хээрийн нөхцөлд ажиллах бэлтгэл;

- Холбооны зангилгаа, штабын хамгаалалтыг хүчжүүлэх ажиллагаа;

- Маршрутын дагуух тагнуул, комендантын албаны зохион байгуулалт;

- Ангийн удирдлага ба хангалтын салбаруудын байнгын байрлалаас дадлагын районд гарах ажиллагаа зэрэг штабаас гүйцэтгэх бүхий л үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж буйд хяналт тавина.

Газар орон дээр явагдах штабын нэгдсэн дадлагыг анги, байгууллагын удирдлагын байнгын байрлалаас эсвэл суралцагчдыг эхлэх районд гарсны дараа эхлүүлж болно.

Суралцагчдыг эхлэх районд гаргахдаа “Цугларалт” дохио өгөх буюу өгөхгүй байж болно. Анги, байгууллагын штабыг “Цугларалт” дохиогоор гаргах нь офицеруудын бэлэн байдлыг шалгах, тэдгээрийн өөрийн албан тушаалын үүргээ хурдан шалмаг, оновчтой биелүүлэх, ажиллах ур чадвар, арга барилыг нэмэгдүүлснээр цэргийн удирдлагын бүрэлдэхүүн, хүч, хэрэгслийн бэлэн байдлыг байнга өндөр түвшинд барьж байх ач холбогдолтой.

Штабын дадлага явуулахдаа хүч хуралдуулах район буюу тактикийн даалгаварын дагуу өөр районыг сонгож

болно. Дадлагын сэдэв, зорилго, явуулах арга хэлбэрээс шалтгаалж, тактикийн даалгаварыг суралцагчдад байнгын байрлалд, хүч хуралдуулах бэлтгэл район руу хөдөлгөөн үйлдэх үед, эсвэл эхлэх районд гардуулж болно. Доод нэгжүүдийн удирдлагын байрууд нь өөр хоорондоо буюу дээд штабтайгаа тодорхой зайтай байралсан байна.

Өгөгдсөн цагийн байдлын дагуу суралцагчид удирдлагын байрыг шуурхай нууцаар шилжүүлэн дэлгэн байгуулж, өнгөлөн далдлалт хийх, харуул хамгаалалтыг зохион байгуулж буй байдалд сургуулийн удирдагч биечлэн хяналт тавьж ажиллана.

Энэ үед эсрэг талын гэнэтийн халдлагын үед суралцагчид өөрсдийнхээ үүргээ хэрхэн мэдэж буй, удирдлагын байрыг хамгаалах хүч хэрэгслийг зохион байгуулж байгаа байдалд захирагч, дарга нар онцгой анхаарна.

Томилгоот районд гармагц сургах зорилгоор удирдлагын байруудын элемент бүрийг нормт хэмжээ, зааврын дагуу байрлуулна.

Зураг дээр явуулах штабын нэгдсэн дадлагыг штабын офицерууд, төрлийн цэргийн дарга нарыг тусгайлан төхөөрөмжилсөн танхимд байрлуулж, тактикийн даалгаварыг гол төлөв дадлага эхлэх үед гардуулна.

Удирдлагын байрыг дэлгэх, шилжүүлэн байрлуулах дадлагыг ТЖХ хэлбэрээр районд гарах хөдөлгөөний үед явуулж болно.

ТЖХ-ээр удирлагын байрын хөдөлгөөн үйлдэх, дэлгэх, сонгосон районд туршуул явуулах, комендантын

албаныг зохион байгуулах, цувааны тогтоосон журмыг баримтлан удирдлагын байрын хөдөлгөөн үйлдэх, утсан холбоог бэлтгэх, өнгөлөн дадлалт, шинэ районд гарахаар цуваанд татах зэрэг ажиллагаануудыг дэс дараалан боловсруулна.

Шийдвэр гаргахад шаардагдах тооцоо, санал, өгөгдөхүүн бэлтгэх сэдвээр явагдах дадлага нь Суралцагчдад байлдааны үүрэг хүргэх, захирамж заавар боловсруулахаас эхлэнэ.

Байлдааны үүрэг хүргэсний дараа захирагч албад тасгийн дарга нарт ямар өгөгдөхүүн, тооцоо, саналыг хэдийд бэлэн болгохыг тодорхойлж өгнө.

Суралцагчид заагдсан хугацаанд авсан үүргээ судлан, цагийн байдлыг үнэлж, шаардлагатай тактикийн тооцоонуудыг үйлдэн саналаа бэлтгэнэ.

Хэрэв штабын дадлага нь шийдвэрийг албан ёсны болгох ба байлдааны ажиллагааны төлөвлөлтөөс эхэлж байгаа бол захирагч шийдвэрээ зарлан суралцагчид өөрсдийн зурагт шаардлагатай зүйлсээ шууд оруулна. Энэ үед суралцагчид шийдвэрийг амаар сонсон цэргийн байр зүйн зурагт оруулах дадлагатай болох шаардлага тавигддаг. Захирагчийн шийдвэр зарлахтай нэгэн зэрэг штаб албад, тасгийн дарга нарт захирагчаас төлөвлөлтийн асуудлаар заавар өгөгддөг.

Байлдааны баримт бичгүүд бэлэн болохын хирээр захирагч тэдгээрийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай бол дахин хийх, дутагдлыг засуулахаар буцаан өгнө.

Цагийн байдлын өгөгдөхүүнийг цуглуулах, танилцуулах ажиллагааны үед холбооны нууцласан хэрэгсэл болон цэргийн далдуур удирдлагын баримт бичгийг өргөн ашиглана.

Дадлагын үед захирагч нь штаб, албад, тасгийн ажлыг нарийн зохицуулж, тодорхойлж өгөх ёстой бөгөөд дадлагын зорилгод хүрэхийн тулд штабын дадлагыг эхнээс нь дуустал хугацаанд суралцагч анги, байгууллагын удирдлагын офицеруудыг аль болох өндөр ачаалалтай байлгах шаардлага тавьж ажиллана.

Төлөвлөсөн зорилтоо хангах үүднээс штабын дадлагын бүхий л үйл явцад орчин үеийн нөхцөл байдлыг тусган ажлын ачааллыг бий болгож байвал зохино. Энэ нь:

1. Орчин үеийн байлдааны шинж чанарыг тусгасан түвэгтэй цагийн байдал үүсгэснээр;

2. Ямар нэгэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх цагийг суралцагчдад чанд тогтоож өгснөөр;

3. Удирдлагын бүрэлдэхүүний ажлын нөхцлийг байлдааны байдалд аль болох ойртуулснаар;

4. Суралцагчдын ажиллагаанд захирагчийн зүгээс байнгын хяналт тавьснаар тус тус хэрэгжинэ.

Штабын нэгдсэн дадлагыг **зураг дээр** явуулах үед удирдлага, штабын албад, тасгийн офицерууд өөрсдийнхээ ажлын байранд буюу тусгай бэлтгэгдсэн ажлын байранд байрлана. Энэ үед тактикийн даалгаварыг штабын дадлага эхлэхээс өмнө буюу дадлагыг эхэлмэгц өгч болно.

Штабын дарга байлдааны үүрэг авсныхаа дараа штабын албад, офицерууд ямар тооцоо, өгөгдэхүүн, саналыг хэдийд илтгэхэд бэлэн болгох талаар зааварчилгаа агнө.

Суралцагчид ногдсон хугацаанд бие даан авсан үүргээ судалж, цагийн байдлыг тогтоон, шаардлагтай оператив-тактикийн тооцоо хийж, захирагчийн шийдвэрт оруулах саналыг бэлтгэнэ.

Захирагч нь штабын офицеруудын дадлагын явцад орчин үеийн арга, техник хэрэгслийг ашиглан тактикийн тооцоог хэрхэн хурдан шуурхай хийж буй байдал, албадын дарга нарын харилцан ажиллагааг асуудалд анхаарлаа хандуулна.

Ангийн захирагч тогтоосон журам, дадлагын боловсруулах асуудлын дагуу зарим офицеруудын санал, тооцоог сонсоно. Зарим тохиолдолд штабын нэгдсэн дадлага нь офицеруудын шийдвэрт оруулах санал, тооцоо сонсноос шууд эхэлж болдог. Энэ нөхцөлд суралцагчид дадлага эхлэхээс өмнө тактикийн даагаварыг сайн судалж мэдсэн байх шаардлагатай.

Штабын дадлагын явцад суралцагчид нь бодит нөхцөл байдалд ойртуулж шийдвэр гаргахад бүх анхаарлаа хандуулна.

Дадлагын нэг онцлог нь суралцагчдыг богино хугацаанд товч, тодорхой, санал, тооцоогоо илтгэхэд сургах зорилго тавьдаг. Захирагч дадлагын үеэр зарим офицеруудын саналыг сонсч, нэмэлт асуудал тавин илэрсэн дутагдлыг засуулах замаар

суралцагчдад мэдлэг, дадлага олгохыг хичээдэг.

Хэрэв **штабын дадлагыг** байлдааны ажиллагааг төлөвлөх, шийдвэр гаргахаас эхэлсэн тохиолдолд ангийн захирагч эхлээд шийдвэрээ танилцуулж, штаб, албад, тасгийн офицерууд түүнийг газрын зураг дээр оруулна. Үүний нэг ач холбогдолтой тал нь суралцагчид ямар нэгэн урьдчилсан зааварчилгаа авахгүйгээр шийдвэрийг шууд зураг дээр оруулах дадлага олж авдаг.

Гаргасан шийдвэрээ тодорхой, ямар нэгэн сул үггүй, ойлгомжтой, нарийн дараалалтай энгийн байдлаар суралцагчдад танилцуулна.

Зарим тохиолдолд захирагч шийдвэрээ танилцуулахгүйгээр штабын даргын захирагчийн шийдвэрт оруулах саналд шаардлагатай засвар хийж болно. Энэ шийдвэрийг штабын дарга суралцагчдад янз бүрийн аргаар хүргэнэ.

Ангийн захирагч шийдвэрээ зарлахын зэрэгцээ штаб, албадын дарга нарт байлдааны ажиллагааг төлөвлөх талаар зааварчилгаа өгнө. Захирагч нь штаб, төрөл мэргэжлийн албадын дарга нарт ямар баримт бичгүүдийг хэдийд боловсруулж бэлэн болгох талаар зааварчилгаа өгнө.

Сургуулийн удирдагч, ангийн захирагч нар нь штабын дадлагын явцад офицеруудыг хурдан сэтгэх, шуурхай ажиллах, туршлага хуримтлуулах, шийдвэр гаргах, байлдааны бичиг, баримт боловсруулах хугацааг багасгах, бий болсон цагийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, байлдааны үүргийг богино хугацаанд

цэрэгт хүргэх дадлага, чадвар олгох асуудлыг биечлэн хариуцна.

Хоёр шатны штабын дадлагын үед ангийн захирагч гол анхаарлаа анги, байгууллагын штабын байлдааны ажиллагааны төлөвлөлт, захирагдсан ангиудын штабуудын төлөвлөлтийг нэгэн зэрэг явуулахад хандуулна.

Захирагдсан ангийн штаб, салбаруудад байлдааны урьдчилсан захирамж, байлдааны тушаал, харилцан ажиллагаа, байлдааны бүх төрлийн хангалтын тухай зааварчилгааг амаар буюу бичгээр хурдан шуурхай хүргэхэд офицеруудыг сургаж, дадлагажуулахад ангийн захирагч анхаарч ажиллана.

Харин суралцагч анги, салбарын дарга нар штабын дадлагын явцад дээд штабаас авсан захирамжийг үндэслэн өөрсдийн штабын офицеруудыг сургах, хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу бүх сургуулийн асуудлыг боловсруулах зорилт тавина.

Ангийн захирагч удирдлагад буй анги, салбарууд руу илгээх байлдааны баримт, бичгүүдийг батлах буюу гарын үсэг зурна.

Штабын нэгдсэн дадлага явуулах төлөвлөгөөний дагуу ангийн захирагч нь шийдвэр, харилцан ажиллагааг газар орон дээр тодотгоход оролцох албан тушаалтнуудыг сонгон, тэдний мэдлэг, дадлага, чадварыг сайжруулах анхаарч ажиллана.

Хэрэв **штабын дадлага** нь байлдааны явцад цэргийг удирдах үйл ажиллагаанаас эхлэсэн тохиолдолд хичээлийн эхэнд холбогдох цагийн байдал өгнө. Дадлагын сэдэв, зорилгоос хамааран тухайн цагийн

байдлыг нэгнээс нь нөгөө рүү шилжүүлэх буюу үсрэлтийн байдлаар хөгжүүлнэ.

Тухайлбал, цагийн байдлыг хүлээн авч, нэгтгэх, дүн шинжилгээ хийх эсвэл байлдааны ажиллагааг удирдах үед цагийн байдлыг нэгнээс нөгөө рүү шилжих замаар дэс дараалан хөгжүүлэх нь илүү зохимжтой байдаг. Энэ үед хийсвэр болон бодит цаг нь хоорондоо зөрүүгүй байна. Боловсруулж буй сургуулийн асуудал нь өөр хоорондоо уялдаагүй бол тухайн цагийн байдлыг суралцагчдад үсрэлтийн байдлаар өгч, дараагийн боловсруулах асуудал руу шууд шилжинэ. Ямар ч тохиолдолд өгөгдсөн цагийн байдлыг суралцагчдад янз бүрийн сувгаар хүргэж болно.

Цагийн байдлыг ихэвчлэн холбооны техник хэрэгсэл ашиглан амаар илтгэн хөгжүүлж, бусад тохиолдолд цагийн байдлыг бичгээр буюу график хэлбэрээр өрнүүлж болно.

Хоёр шатны штабын дадлагын үед суралцагч штабуудад өөрийн анги, салбар болон эсрэг талын тухай өгөгдөхүүнийг сургууль эхлэхээс өмнө захирамж, байлдааны мэдээгээр хүргэсэн байна. Зэргэлдээ салбарын цагийн байдал, ахлах даргын хэрэгслээр олзворлосон тагнуулын мэдээг дээд шатны штабаас суралцагчдад төрөл бүрийн сувгаар дамжуулна.

Цагийн байдлыг мэдээг цуглуулж нэгтгэх үед суралцагчид холбооны нууцалсан техник хэрэгсэл ашиглан ярих дадлага хийх, цагийн байдлыг холбоогоор хүлээн авч ажлын зураг дээр үнэн зөв оруулах, суралцагч штаб,

төрөл мэргэжлийн албад, тасгийн дарга нарт бий болсон цагийн байдал, шийдвэрт оруулах санал, дүгнэлтийг бэлтгэх тухай цаг алдалгүй мэдээлж байна. Үүний дараа ангийн захирагч шийдвэрээ танилцуулж, хэнд захирамж өгөх талаар зааварчилгааа өгнө. Суралцагчдад техник хэрэгсэл ашиглан байлдааны захирамж хүргэнэ.

Дадлагаар офицеруудыг хүндрүүлсэн цагийн байдалд цэргийг удирдах дадлага олгох, радио саатуулга хийж, холбоо тасарсан үед суралцагчдыг ажиллаж сургах асуудлыг давхар боловсруулна.

Ангийн захирагч хөдөлгөөний үед холбооны хэрэгсэл ашиглан, цагийн байдлыг хөгжүүлэн, удирдлагын байрыг шилжүүлэх тухай зааварчилгааа өгнө. Энэ үед удирдлагын байрыг байрлуулах шинэ газар болон хөдөлгөөний маршрут, очих хугацааг заана.

Захирагч зааварчилгаа өгснийхөө дараа штабын дарга, оперативын тасаг, холбооны даргын саналыг сонсоно. Удирдлагын байрыг шилжүүлэн байрлуулахдаа хордсон газар орон, химийн бодисын хордуулалт, нуранги, байгалийн саад болон түймэртэй районуудыг туулахаар төлөвлөнө.

Штабын нэгдсэн дадлагын үед захирагч, суралцагчдын үйл ажиллагаа нь байлдааны цагийн байдалд ойртуулсан нөхцөлд явагдана. Дадлагын үед суралцагчдын ажлын багтаамж нь хэд хэдэн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Суралцагчдын цагийн байдлын талаар хийсэн дүгнэлт, шийдвэр гаргахад шаардлагатай тооцоо,

өгөгдөхүүнүүд, зарим тохиолдолд өргөн хүрээг хамарсан асуудлуудыг захирагч тусгаж өгөхийн зэрэгцээ байлдааны цагийн байдалд аль болох ойртуулна. Энэ нь штабын офицеруудын оператив-тактикийн сэтгэлгээг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол өгдөг. Захирагч, штаб, төрөл мэргэжлийн албадын дарга нарын ажлын шинж чанарын талаар суралцагчдад буруу ойлголт өгөхгүй байхыг хичээх хэрэгтэй.

Штабын дадлагын явцад захирагч нь удирдлагыг гартаа авч чаддаг байх шаардлагатай. Ангийн захирагч нь штаб, төрөл мэргэжлийн дарга нарын ажлыг маш тодорхой зааж өгөх үүрэгтэй. Мөн суралцагч офицеруудын бие даан санаачлага гаргах бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхээс гадна, тэдгээрийн зохион байгуулах чадвар, дадлагыг нэмэгдүүлж, штаб, төрөл мэргэжлийн дарга нарын саналыг сонсож батлана.

Захирагч нь штабын дадлагыг сургамжтай явуулахын тулд анги, байгууллагын шийдвэрийг зарлаж, суралцагчдад байлдааны үүрэг тавьж, шаардлагатай тохиолдолд энэ ажлыг хэрхэн зөв зохион байгуулахыг биечлэн үзүүлж болно.

Штабын нэгдсэн дадлага нь урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний дагуу явагдана. Сургуулийн асуудлыг боловсруулахын тулд захирагчийн шийдвэрт оруулах саналыг суралцагчид үндэслэл сайтай гаргана.

Штабын дадлага явуулах төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлт, тодотголыг тухай бүр нь хийнэ.

Эсрэг талын болон өөрийн цэргийн байдал, байрлал, бүрэлдэхүүн, болзошгүй ажиллагааны шинж чанарыг зөв тодорхойлж, ажлын зураг дээр холбогдох өгөгдөхүүнийг оруулсан байна.

Нисдэг тэрэгний нислэгийн үед анги, байгууллагын газрын удирдлагын байртай тасралтгүй холбоо барьж, байлдааны баримт бичгийг хурдан шуурхай боловсруулна.

Агаараас байгалын саад, замын сүлжээ, газар орны өнгөлөн далдлалтын байдал, гадаргуугийн онцлогийг судалж, үнэлнэ.

Офицеруудын бэлтгэлийн түвшингээс шалтгаалж, штабын дадлагыг дараалсан буюу цогц хэлбэрээр явуулна. Штабын дадлагыг тактикийн хээрийн сургуультай хослуулан явуулах нь ач холбогдолтой болдог.

Сургуулийн боловсруулсан асуудал бүрийн төгсгөлд хэсэгчилсэн дүн гаргаж, суралцагчдын ололт, дутагдалтай талыг тэмдэглэж, дутагдлыг засах арга хэмжээ авна.

Штабын хэсэгчилсэн дадлага явуулах онцлог.

Штабын хэсэгчилсэн дадлага нь суралцагчдын хичээлд бэлтгэсэн байдлыг шалгах аас эхлэнэ. Сургуулийн удирдагч офицеруудад сэдэвтэй холбогдолтой асуулт тавьж тэдгээрийн онолын мэдлэгийг шалгаж, цагийн байдал, байлдааны үүргийн талаар асууна. Үүнээс гадна зураг дээр цагийн байдлыг үнэн зөв оруулсан эсэхийг шалгана. Шалгалтын явцад офицер бүрийн дутагдалтай талыг тэмдэглэж, түүнийг засах талаар зөвлөгөө өгнө.

Үүний дараа штабын дадлагын удирдагч хийсвэр цагийг зарлаж, суралцагчдад анги, байгууллагын байлдааны үүргийг амаар хүргэж, шинэ цагийн байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зааварчилгаа, бусад өгөгдөхүүнийг хүргэнэ.

Суралцагчид авсан үүргээ бие даан биелүүлж, энэ тухайгаа сургуулийн удирдагчид илтгэнэ. Бүх суралцагч офицерууд нь сургуулийн асуудлаа янз бүрийн арга хэлбэрээр боловсруулж, дүгнэлт хийнэ.

Штабын хэсэгчилсэн дадлагад штаб, ажиллагааны удирдлагын тасгийн офицерууд байлдааны шийдвэрийн өгөгдөхүүнүүдийг бэлтгэх, тооцоо гаргах асуудлыг боловсруулж болно. Жишээлбэл, хүч хэрэгслийн болон төрөл бүрийн тооцоо гаргах асуудлыг дангаар нь боловсруулж болно.

Тэрчлэн байлдааны ажиллагааг төлөвлөх, харилцан ажиллагааны бүдүүвч болон бусад байлдааны баримт бичгийг боловсруулах асуудлыг сонгоно.

Суралцагчдын хийсэн ажлыг шалгаж үнэлсний дараа дараачийн сургуулийн асуудал боловсруулах цагийн байдлыг өгнө.

Штабын хэсэгчилсэн дадлагын үед офицеруудад анхан шатны штабын дадлага олгохын тулд бүлгийн дасгалын хичээлийн хэлбэрт шилжүүлж, байлдааны ямар нэгэн баримт бичгийг элемент тус бүрээр нь боловсруулах дадлага хийлгэж болно.

Энэ үеэр офицеруудад штабын ажлын анхан шатны дадлага олгох зорилготой аль нэгэн баримт бичгийг

боловсруулах, бүлгийн хичээлийг элемент бүрээр нь гүйцэтгэвэл зохих юм.

Офицеруудад бие биенээ орлон ажиллах чадвар олгох, түүнийг дээшлүүлэх зорилгоор бүх офицерууд нэг баримт бичгийг боловсруулна. Дараа нь өөр албан тушаалтных гэх мэтээр офицерууд, албад, тасгийн бүх л хүрээг хамарснаар цэргийг удирдах явцад бие биенээ орлож үүрэг гүйцэтгэх боломжтой болдог.

Штабын хэсэгчилсэн дадлагыг суралцагчдыг тухайн албан тушаалд нь буюу өөр албан тушаалд сургахын тулд ямар ч аргаар явуулдаг. Зарим тохиолдолд сургуулийн удирдагч дадлага эхлэхээс өмнө суралцагчдыг тоглох албан тушаалд нь хуваарилж сургуулийг эхлүүлнэ. Энэ тохиолдолд суралцагчид нь хичээлийн үеэр ээлж, дараагаар төрөл мэргэжлийн албадын даргын албан тушаалд байлдааны баримт бичиг боловсруулах болон цэргийн удирдлагатай холбоотой бусад тавигдсан үүргийг биелүүлнэ.

Бүлгийн дасгал²²⁷ нь суралцагчид нэг байранд байрлаж, сургуулийн удирдагчийн өгсөн үүргийн дагуу байлдааны баримт бичгийн ямар нэгэн хэсгийг бие даан боловсруулахад чиглэгдэнэ. Жишээ нь, байлдааны мэдээний нэгдүгээр пунктыг боловсруулж болно. Дараа нь 2-3 офицерийн илтгэлийг сонсч товч дүн гаргана.

Хамгийн гол нь бүх офицерууд баримт бичгийг товч тодорхой, зөв боловсруулсан байна. Шаардлагатай үед сургуулийн удирдагч тухайн пунктыг боловсруулсан өөрийнхөө хувилбарыг танилцуулна. Ийм дарааллаар дараагийн байлдааны баримт бичгийг боловсруулж болно.

Бусад тохиолдолд штабын дадлагын үеэр бүх суралцагчид өөр төрлийн байлдааны баримт бичиг боловсруулах, тусгай үүрэг гүйцэтгэнэ. Ийм байдлаар дараагийн хичээлд офицерууд бусад төрлийн баримт, бичгийг боловсруулах дадлага, сургууль хийнэ. Үүний үр дүнд төрөл мэргэжлийн албадын дарга нар оногдсон үүргээ биелүүлэх дадлага эзэмшиж, цэргийг удирдлагаар хангах, харилцан ажиллагаа зохион байгуулах өргөн боломж бий болгодог.

Штабын дадлагын дүнг гаргах.

Штабын нэгдсэн болон хэсэгчилсэн дадлагын дүнг удирдагч биечлэн гаргана. Дүнг гаргахдаа дадлагын сэдэв, зорилго, тактикийн ажиллагааны бодлого, дадлагын явцыг мэдээлж, шийдвэртэй холбоотой илтгэлүүдийн агуулга, суралцагчдын ажиллагааг дүгнэн ололт, дутагдлуудыг тодорхой заана. Эцэст нь штабын дадлагын зорилт ямар түвшинд хангагдсаныг үнэлэн тасаг, албад бүрийн дүн, штабын дадлагын ерөнхий дүн, гар нийлэмжтэй ажиллагаа ямар байдалд байгаад дүгнэлт хийж, илэрсэн дутагдлуудыг засах талаар штабаас

²²⁷ В.Жавхланцогт, Ж.Өвгөнбүргэд, “Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь” УБ., 2017 он 76 дах тал

авах арга хэмжээг зааж өгснөөр дадлага дуусна.

Дадлагын дүнг хүн нэг бүрээр нь гаргахдаа албан тушаалтнуудын идэвхи санаачлагатай байдал, оролцоо, мэдлэг, ур чадварын түвшингийн ахицийг харгалзан үнэлнэ.

Сургуулийн дүнг цаг тухайд нь гаргахын тулд штабын дадлагыг эхлэхээс дуусах хүртэл бэлтгэл ажлыг хангасан байна. Дадлага эхлэх хүртэл сургуулийн удирдагч тактикийн ажиллагааны бодлогын схемийг бэлтгэх, сэдэвтэй холбоотой онолын асуудал судлах, өмнөх сургуулийн жилүүдийн болон байлдааны туршлага зэргийг харгалзан үзнэ.

Дадлагын явцад суралцагчдын үйл ажиллагаа, боловсруулсан баримт

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ:

Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016

Ц.Ганболд, Д.Баатар, “Штабын сургалт, бэлтгэл” УБ., 2013

В.Жавхланцогт, Ж.Өвгөнбүргэд, “Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь” УБ., 2017

бичгийн агуулгыг биечлэн хянаж, дүгнэлт гаргасан байна.

Сургуулийн удирдагч, суралцагчидын дутагдалтай үйл ажиллагаанд тодорхой дүгнэлт хийсэн байх ёстой.

Дүнгийн төгсгөлд сургуулийн удирдагч штабын дадлагаар дэвшүүлсэн сургуулийн зорилго биелэгдсэн байдал, төрөл мэргэжлийн цэргийн дарга нарын бэлтгэлийн түвшин, штабын гар нийлэмжтэй ажиллагааны талаар үнэлэлт өгч, дадлагын үеэр илэрсэн дутагдлыг засахын тулд ойрын үед ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тодорхой зааж өгнө.

Г.Мягмаржав, “Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс” УБ., 1999

Ц.Энхжаргал, “Хил хамгаалах байгууллагын офицерын сургалт бэлтгэлийн тогтолцоо, түүнийг сайжруулах арга”. УБ., 2020